



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

### ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

ОНХС-гийн хөрөнгийн тодорхой хэсгийг машин, техник, тоног төхөөрөмж худалдан авах, урсгал зардлыг санхүүжүүлэх зэргээр тухайн байгууллагын төсвийн цоорхойг нөхөх эх үүсвэр болгон, хэт жижиглэн зарцуулж байгаа нь тус сангийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.



Сүхбаатар сум  
2017 он

## АГУУЛГА

**Тайланг бэлтгэсэн:**

Сэлэнгэ аймгийн  
Аудитын газар

Тэргүүлэх аудитор  
Ч.Энхтуяа

Аудитын менежер  
Б.Батмөнх

Ахлах аудитор  
Б.Наранчимэг  
С.Бат-Эрдэнэ

Аудитор  
Б.Эрдэнэзул  
Ц.Отгонбаяр

Шинжээч  
С.Баасансүрэн  
А.Дашбат  
Ц.Уртнасан

Аудитын  
тайлан, дүгнэлттэй  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл гарвал  
70362442, 70363047,  
70363040 дугаарын  
утас, 70363040  
дугаарын факсаар  
харилцана уу.

**Товчилсон үгийн тайлбар**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй  
Үндсэн мэдээлэл**

**1. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл бүрээр төлөвлөхгүй байна.**

1.1 Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн боловч тодотгосон төсвийн дагуу дахин хуваарилалтыг хийхдээ зохих аргачлалыг мөрдөөгүй байна.

1.2 Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

1.3. Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлээгүй байна.

1.4 ОНХС-гаас олгосон орлогын шилжүүлгийн 54.7 хувийг сумдад хуваарилж, санхүүжилтийг 1.6 хувиар буюу 41.2 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

**2. ОНХС-гийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.**

2.1 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж батлаагүй байна.

2.2 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.

2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй, магадлал хийлгээгүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байна.

2.4 Сумдад худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлээр нэгдсэн заавар чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байх шаардлагатай байна.

2.5 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээний 4.9 хувь буюу 260.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.6 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.

2.7 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй байна.

**3. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт гүйцэтгэх байгууллагууд хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.**

3.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

3.2. Сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг авч, тайланд дүн шинжилгээ хийн, зөвлөмж хүргүүлэх ажил хийгдээгүй байна.

3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний мэдээллийг нийтэд ил тод хүргэж байна.

3.4. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын зарим заалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

3.5 Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 82.5 хувьтай байна.

**Илрүүлсэн зөрчил**

**Дүгнэлт**

**Зөвлөмж**

**Хавсралт судалгаа**

**ХАЯГ:**Сэлэнгэ  
аймгийн  
ЗДТГ-ын байрны  
өргөтгөлд

2017 оны 4 дүгээр сар

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|                     |                                                                                        |
|---------------------|----------------------------------------------------------------------------------------|
| <b>АЗДТГ</b>        | Аймгийн Засаг даргын Тамгын газар                                                      |
| <b>ЕБС</b>          | Ерөнхий боловсролын сургууль                                                           |
| <b>ЗДТГ</b>         | Засаг даргын Тамгын газар                                                              |
| <b>ИТХ</b>          | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал                                                           |
| <b>ИНХ</b>          | Иргэдийн нийтийн хурал                                                                 |
| <b>ОНӨААТҮГ</b>     | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                   |
| <b>ОНХС</b>         | Орон нутгийн хөгжлийн сан                                                              |
| <b>ОНХНС</b>        | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан                                                      |
| <b>СТСХ</b>         | Санхүү, төрийн сангийн хэлтэс                                                          |
| <b>ТБОНӨБАҮХАТХ</b> | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| <b>ТЕЗ</b>          | Төсвийн ерөнхийлөн захирагч                                                            |
| <b>ТОӨЗ</b>         | Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа                                                  |
| <b>ТЭЗҮ</b>         | Техник, эдийн засгийн үзүүлэлт                                                         |
| <b>ХОХБТХ</b>       | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс                                |
| <b>ХХААХҮЯ</b>      | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам                                             |
| <b>ХХК</b>          | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                                   |
| <b>УИХ</b>          | Улсын Их Хурал                                                                         |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### 1. Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

### 2. Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн эсэх.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан эсэх.

### 3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын СТСХ болон ХОХБТХ, Худалдан авах ажиллагааны алба, сумдын төрийн сангийн төлөөлөгч, ОНХС хариуцсан мэргэжилтэн зэрэг албан тушаалтнууд, ОНХС-гийн хөрөнгийн 2016 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзлээ.

### 4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөөний дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

### 5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ТБОНӨХБАУХА тухай хууль,

- Барилгын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол,
- Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”,
- 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”,
- Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжууд болон холбогдох бусад хууль эрхийн актууд

## 6. Үндсэн мэдээлэл

2016 онд аймаг, сумдын ОНХС-д мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 443.0 сая төгрөгийн, авлагаас 0.9 сая төгрөгийн, ОНХНС-гаас 4,887.3 сая төгрөгийн зэрэг нийт 5,331.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөн, төлөвлөсөн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар ОНХНС-гаас Сэлэнгэ аймагт хуваарилсан 4,887.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн 15 дугаар тогтоолоор аймагт 2,223.6 сая төгрөгийг, сумдад 2,663.7 сая төгрөгийг хуваарилан, баталсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр өмнөх оноос хэрэгжиж эхэлсэн санхүүжилт дутуу 1,108.0 сая төгрөгийн өртөг бүхий 54 төсөл, арга хэмжээ, тайлант онд шинээр эхлэх 4,213.2 сая төгрөгийн өртөг бүхий 148 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 4,447.2 сая төгрөгийн 184 төсөл арга хэмжээг бүрэн, 529.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлсэн бөгөөд 399.7 сая төгрөгийн өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

**Бүлэг 1**

**ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх.**

*ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл бүрээр төлөвлөхгүй байна.*

**1.1 Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн боловч тодотгосон төсвийн дагуу дахин хуваарилалт хийхдээ зохих аргачлалыг мөрдөөгүй байна.**

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлал, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврыг үндэслэл болгон ОНХС-гаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг 4 итгэлцүүрт<sup>1</sup> /орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилгын индекс/ үндэслэн хуваарилахаар зохицуулагдсан байдаг.

УИХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 2016 оны Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд ОНХС-гаас Сэлэнгэ аймгийн ОНХС-д 7,472.6 сая төгрөгийн шилжүүлэг олгохоор анх баталсан бол Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар 34.6 хувиар бууруулан 4,887.3 сая төгрөг болгон тодотгосон байна.

Үүний дагуу аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Төсөв батлах тухай” 74 дүгээр тогтоол, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Тодотгосон төсөв батлах тухай” 15 дугаар тогтоолоор ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдэх төсөл, арга хэмжээг тус тус баталжээ.

Анх батлагдсан ОНХС-гаас олгох шилжүүлгийн төсвийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс сумдад хуваарилахдаа хүн амын тоо, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн татварын идэвх санаачилга гэсэн 3 итгэлцүүрийг тус бүр 33.3 хувиар харгалзуулан тооцсон байна.

Аймаг, сумын хөгжлийн индексийг Засгийн газрын 2010 оны 88<sup>2</sup>, 2014 оны 242 дугаар тогтоол<sup>3</sup>-ын дагуу Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос тооцон гаргаж, нийтэд мэдээлж байхаар баталсан ч өнөөг хүртэл хэрэгжээгүй тул ОНХС-гийн эх үүсвэрийг сумдад хуваарилахдаа хөгжлийн индексийг авч үздэггүй байна.

Харин Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн тогтоолоор тодотгон батлагдсан 4,887.3 сая төгрөгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа тус хуулийн 2 дугаар зүйлийн е-д “спорт цогцолбор, усан бассейн, соёлын төвийн хөрөнгө оруулалтыг шинээр эхлүүлэхгүй байх, цэцэрлэг, сургуулийг түрээсийн зарчмаар

<sup>1</sup> Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9.2 дэх “аймаг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сумын ОНХС-д хуваарилахдаа энэ аргачлалын 3-р зүйлд заасан мэдээллийг ашиглан 4-8 дугаар зүйлд заасан 4 төрлийн итгэлцүүрийг орон нутгийн үзүүлэлтэд дүйцүүлэн тогтооно.

<sup>2</sup> Хөгжлийн индексийн тухай

<sup>3</sup> Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай

ажиллуулах, төсвийн хөрөнгөөр баригдсан үйл ажиллагаа нь эхлээгүй, дутуу баригдсан барилга, байгууламжийг зарж борлуулах, төсвийн үр ашиггүй хөрөнгө оруулалтыг эхлүүлэхгүй байх” гэж заасныг мөрдлөг болгон өмнө нь батлагдсан, хэрэгжиж эхлээгүй байсан төсөл, арга хэмжээг жагсаалтаас хасах замаар хуваарилсан байна.

Тодотгосон төсвийг зохих журмын дагуу дахин тооцоолол хийж хуваарилаагүйгээс сумдын ОНХС-д 60 хүрэхгүй хувийг /2,663.8 сая төгрөг буюу 54.5 хувийг/ хуваарилснаас гадна 8 суманд 11.8-126.1 сая төгрөгийн дутуу, 9 суманд 4.3-61.6 сая төгрөгийн илүү төсөв хуваарилж, баталсан байна. / Хүснэгт 1/

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлтүүд                                                                     | Алтанбулаг | Баруунбүрэн | Баянгол | Ерөө   | Жавхлант | Зүүнбүрэн | Мандаг | Орхон  | Орхонтуул | Сайхан | Сант   | Сүхбаатар | Хушаат | Хүдэр   | Түшиг | Цагааннуур | Шаамар | Сэлэнгэ аймаг | НИЙТ    |
|---------------------------------------------------------------------------------|------------|-------------|---------|--------|----------|-----------|--------|--------|-----------|--------|--------|-----------|--------|---------|-------|------------|--------|---------------|---------|
| ОНХС-аас олгох шилжүүлгийг сумдад зохих журмын дагуу дахин тооцоолж хуваарилсан | 137.4      | 172.9       | 157.2   | 238.6  | 111.6    | 102.1     | 380.5  | 138.0  | 168.8     | 184.6  | 138.0  | 272.9     | 135.7  | 156.0   | 156.1 | 173.3      | 108.8  | 1,954.9       | 4,887.3 |
| Тодотгосон төсвөөр хуваарилсан дүн АИТХ-ын 2016.12.02 №15 тогтоол               | 49.0       | 234.6       | 31.1    | 162.0  | 87.7     | 160.8     | 385.6  | 94.9   | 178.8     | 188.9  | 126.1  | 150.9     | 160.8  | 49.5    | 207.5 | 230.0      | 165.4  | 2,223.6       | 4,887.3 |
| Зөрүү                                                                           | (88.4)     | 61.6        | (126.1) | (76.6) | (23.9)   | 58.8      | 5.1    | (43.1) | 9.9       | 4.3    | (11.8) | (122.0)   | 25.1   | (106.4) | 51.4  | 56.7       | 56.6   | 268.6         | (0.0)   |

## 1.2 Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөөгүй байна.

Аймаг, сумдын төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн төсөлд аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.2<sup>4</sup>, 14.2.4<sup>5</sup>, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын 2.2.2<sup>6</sup>, 2.2.3<sup>7</sup>, 2.2.4<sup>8</sup>, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан журмын 6.1<sup>9</sup>-д заасан нэр төрлөөр нь тооцож, тусгаагүй байна.

2016 онд аймаг, сумдын ОНХС-гийн эх үүсвэрийг зөвхөн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийн дүнгээр төлөвлөсөн бөгөөд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр, аймгийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламжийн зэрэг эх үүсвэрүүдийг тооцоолж, төлөвлөөгүй байна.

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, сумдын Санхүү, албаны дарга нартай асуулга, ярилцлага хийхэд:

- Сангийн яам урсгал үйл ажиллагааны төсвийн төслийг хянан хүлээж авдаг ч ОНХС-гийн болон хөрөнгө оруулалтын зардлыг хянаж, хүлээж авдаггүй,
- ОНХС-гийн эх үүсвэрийг хэрхэн тооцоолж, төлөвлөх талаар нэгдсэн заавар, чиглэл өгөгддөггүй тул нарийн төлөвлөдөггүй,

<sup>4</sup> Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох

<sup>5</sup> Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухай төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах

<sup>6</sup> Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хөрөнгө

<sup>7</sup> Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн тэнцлийн ашиг

<sup>8</sup> Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болсон нэмэгдэл эх үүсвэр

<sup>9</sup> 6.1 Аймаг, нийслэлийн Засаг дарга ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны ОНХС-ийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө: 6.1.1 ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг; 6.1.2 аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг 6.1.3 татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр; 6.1.4 зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр; 6.1.5 тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж;

- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, тооцооллыг авч үзэлгүйгээр Сангийн яамнаас ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг шууд хуваарилан баталж өгдөг бөгөөд үүний дагуу аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөдөг гэсэн тайлбарыг өгч байна.

Үүнээс үзэхэд аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тооцоолж, тусгалгүйгээр Сангийн яамнаас шууд баталж ирсэн байна.

### 1.3 Аймаг, сумын ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлээгүй байна.

Тайлант онд аймаг болон сумдын ОНХС-д мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 443.0 сая төгрөгийн, авлагаас 0.9 сая төгрөгийн, ОНХС-гаас 4,887.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийн зэрэг нийт 5,331.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөн, санхүүжилтийг бүрэн авсан байна.

Гүйцэтгэлээр дээрх төлөвлөсөн 5,331.2 сая төгрөгийн эх үүсвэрээс гадна 4 суманд дараах 6.6 сая төгрөгийн орлого төвлөрснөөр нийт 5,337.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна Үүнд:

- Мандал, Баянгол сумдад тендерийн материалын нийт 0.1 сая төгрөгийн,
- Ерөө суманд Болд төмөр Ерөө гол компанийн хандиваар бүрдэж, аж ахуйн нэгж, иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээл олгож байсан Хөгжлийн сангийн үлдэгдэл 5.5 сая төгрөгийг ОНХС-гийн дансанд төвлөрүүлсэн,
- ХХААХҮЯамны шугамаар 2010-2013 оны хооронд Жавхлант суманд хэрэгжсэн Хот орчмын бэлчээрийн төслийн хүрээнд иргэдээс авах зээлийн эргэн төлөлт 1.0 сая төгрөгийг ОНХС-гийн дансанд төвлөрүүлсэн байна.

ОНХС-гийн эх үүсвэрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 /сая төгрөг/

| Үзүүлэлтүүд                     | Сумдын ОНХС эх үүсвэр        |           | Аймгийн ОНХС эх үүсвэр |           | НИЙТ       |           |
|---------------------------------|------------------------------|-----------|------------------------|-----------|------------|-----------|
|                                 | Төлөвлөгөө                   | Гүйцэтгэл | Төлөвлөгөө             | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 350.7                        | 350.7     | 92.3                   | 92.3      | 443.0      | 443.0     |
| Авлагын эхний үлдэгдэл          | 0.9                          | 0.9       |                        |           | 0.9        | 0.9       |
| Эх үүсвэр                       | ОНХС-аас олгох шилжүүлэг     | 2,663.7   | 2,622.5                | 2,223.6   | 4,887.3    | 4,887.3   |
|                                 | Журмын дагуу бусад эх үүсвэр |           |                        |           | -          | -         |
|                                 | Бусад тооцоолоогүй орлого    |           | 6.6                    |           | -          | 6.6       |
| Нийт эх үүсвэрийн дүн           | 3,015.3                      | 2,980.7   | 2,315.9                | 2,357.1   | 5,331.2    | 5,337.8   |

2013 оноос үүссэн нийт 8.9 сая төгрөгийн авлагыг дараах сумдын ОНХС-д төвлөрүүлж, зарцуулах боломжтой боловч өнөөг хүртэл төвлөрүүлээгүй байна. Үүнд:

- Ерөө сум нь 2014 онд “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын техник хяналтын зардалд 1.4 сая төгрөгийг илүү шилжүүлснийг буцаан төлүүлээгүй,
- Сайхан сум нь 2014 онд “Дулаан орц” хөтөлбөрийг гүйцэтгэсэн “Өлзийт хөтөл” ХХК-д 1.4 сая төгрөгийн санхүүжилт илүү олгон, 2015 онд шүүхэд шилжүүлсэн боловч өнөөг хүртэл барагдаагүй,
- Сант сум нь 2013 онд гэрэлтүүлгийн ажил хийж гүйцэтгэсэн Автомастер ХХК-д техникийн хяналтын зардлыг 0.1 сая төгрөгөөр илүү шилжүүлснийг барагдуулаагүй,
- Түшиг сум нь 2013 онд цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр Баатарбулаг ХХК-ийг шалгаруулж, гэрээний дагуу 6.0

сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч уг ажлыг хийж гүйцэтгээгүй байна. 2015 онд Түшиг сумын ЗДТГ нь тус компанийг шүүхэд шилжүүлсэн боловч өнөөг хүртэл шийдэгдээгүй байна.

#### 1.4 ОНХНС-гаас олгосон орлогын шилжүүлгийн 54.7 хувийг сумдад хуваарилж, санхүүжилтийг 1.6 хувиар буюу 41.2 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар ОНХНС-гаас Сэлэнгэ аймагт хуваарилсан 4,887.3 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн 15 дугаар тогтоолоор аймагт 2,223.6 сая төгрөгийг, сумдад 2,663.7 сая төгрөгийг хуваарилан баталсан байна.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д 2,663.7 сая төгрөг олгохоор төлөвлөснөөс 6 суманд нийт 41.2 сая төгрөгийг дутуу олгосноор 2,622.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бол аймгийн ОНХС-д сумдад олгох санхүүжилтийг авч үлдсэнээр 2,264.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Холбогдох журмын дагуу орлогын шилжүүлгийг хуваарилаагүйгээс 54.5 хувийг сумдад олгохоор баталж, 53.7 хувийн санхүүжилтийг олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /сая төгрөг/

| №  | Сумдын нэр                    | АИТХ-ын 16.12.02<br>өдрийн 15<br>тогтоолоор баталсан<br>орлогын шилжүүлэг | Санхүүжилтийн<br>гүйцэтгэл 16.12.31<br>байдлаар | Зөрүү         |
|----|-------------------------------|---------------------------------------------------------------------------|-------------------------------------------------|---------------|
| 1  | Алтанбулаг                    | 49.0                                                                      | 49.0                                            | -             |
| 2  | Баруунбүрэн                   | 234.6                                                                     | 234.6                                           | -             |
| 3  | Баянгол                       | 31.1                                                                      | 31.1                                            | -             |
| 4  | Ерөө                          | 162.0                                                                     | 161.0                                           | - 1.0         |
| 5  | Жавхлант                      | 87.7                                                                      | 87.7                                            | -             |
| 6  | Зүүнбүрэн                     | 160.8                                                                     | 160.8                                           | -             |
| 7  | Мандал                        | 385.6                                                                     | 366.3                                           | - 19.3        |
| 8  | Орхон                         | 94.9                                                                      | 89.7                                            | - 5.2         |
| 9  | Орхонтуул                     | 178.8                                                                     | 178.8                                           | -             |
| 10 | Сайхан                        | 188.9                                                                     | 179.7                                           | - 9.2         |
| 11 | Сант                          | 126.1                                                                     | 126.1                                           | -             |
| 12 | Сүхбаатар                     | 150.9                                                                     | 150.9                                           | -             |
| 13 | Хушаат                        | 160.8                                                                     | 160.8                                           | -             |
| 14 | Хүдэр                         | 49.5                                                                      | 47.9                                            | - 1.6         |
| 15 | Түшиг                         | 207.6                                                                     | 202.7                                           | - 4.9         |
| 16 | Цагааннуур                    | 230.0                                                                     | 230.0                                           | -             |
| 17 | Шаамар                        | 165.4                                                                     | 165.4                                           | -             |
|    | <b>Сумдын дүн</b>             | <b>2,663.7</b>                                                            | <b>2,622.5</b>                                  | <b>- 41.2</b> |
| 18 | Сэлэнгэ аймаг                 | 2,223.6                                                                   | 2,264.8                                         | 41.2          |
|    | <b>Дүн</b>                    | <b>2,223.6</b>                                                            | <b>2,264.8</b>                                  | <b>41.2</b>   |
|    | НИЙТ ДҮН                      | 4,887.3                                                                   | 4,887.3                                         | 0.0           |
|    | Нийт дүнд сумын эзлэх<br>хувь | 54.5                                                                      | 53.7                                            | (0.8)         |

ОНХНС-гаас аймаг, сумдын орлогыг оройтож шилжүүлж байгаагаас зарим гэрээт ажил дараа онд шилжих, хүйтний улиралд чанар муутай гүйцэтгэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсч байна.

2016 онд ОНХНС-гаас олгогдсон санхүүжилтийн 41 хувь буюу 2,011.3 сая төгрөгийг 1-7 сард, 33.8 хувь буюу 1,653.8 сая төгрөгийг 9, 11 сард, 25 хувь буюу 1,222.3 сая төгрөгийг 12-р сарын 13-аас 23-ны өдрүүдэд шилжүүлсэн байна.

## Бүлэг 2

**ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль журамд заасны дагуу төлөвлөж, гүйцэтгэсэн үү.**

*ОНХС-гийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.*

### **2.1. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдуулж батлаагүй байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4<sup>10</sup>, 12.1.5<sup>11</sup>, 12.2.5<sup>12</sup>, 12.2.7<sup>13</sup>-д заасны дагуу Засаг дарга нар аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж, тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэх ёстой байдаг.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг хэрхэн гаргасан талаар АЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаас асуулга авахад *“аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон хөрөнгө оруулалтын төсөл бэлтгэх 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сумдаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн, ирүүлсэн тооцоо судалгаа, иргэдээс санал авсан байдал зэргийг хэлэлцэж нэгдсэн жагсаалт гарган батлуулсан”* гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээг Сэлэнгэ аймгийг 2013-2021 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан сонгох ажил хийгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл, сумдын ОНХС-гийн эх үүсвэрээр хийгдэх боломжгүй, өртөг зардал өндөртэй төсөл, арга хэмжээг аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх бодлого барьж төлөвлөж байна.

Сумдын ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулахдаа 13 сум нь багийн ИНХ-аас ирсэн жагсаалтыг Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан, дүн шинжилгээ хийж, нэгдсэн жагсаалтыг гаргасан бол Орхон, Сант, Орхонтуул, Сайхан, Сүхбаатар, Түшиг сумд иргэдээс ирсэн саналыг шууд эрэмбэлэн жагсаалт гаргаж, батлуулсан байна. Үүнд:

- *Орхон сум нь хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлээ албан ёсоор тодорхойлоогүй тул иргэдийн саналыг эрэмбэлж ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөсөн байна.*

<sup>10</sup> Орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;

<sup>11</sup> Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-д заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт хүргүүлнэ.

<sup>12</sup> Сум, дүүргийн ЗДТГ нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална:

<sup>13</sup> Сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

- Сант сумын ажлын хэсэг иргэдээс ирсэн саналыг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийгээгүй, 1-р баг нь санал ирүүлээгүй учир 2-р багийн ирүүлсэн саналыг нэгтгэж, хамгийн их санал авсан дарааллаар нь эрэмбэлсэн байна.
- Түшиг, Сайхан, Орхонтуул, Сүхбаатар сумд ажлын хэсэг томилоогүй, ОНХС хариуцсан мэргэжилтэн нь багийн ИНХ-аас гарсан саналыг нэгтгэж хамгийн их санал авсан дарааллаар нь эрэмбэлсэн байна.

## 2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 3<sup>14</sup> дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12<sup>15</sup> дугаар зүйлд тус тус заасны дагуу иргэд, олон нийтийн оролцоог хангаж, нээлттэй хэлэлцүүлэн санал авч эрэмбэлэхээр зохицуулсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг сумдын нэгдсэн жагсаалт бэлтгэх ажиллагаатай хамт хэрэгжүүлэн, сумдаас ирсэн албан хүсэлт, холбогдох тооцоо судалгаа, иргэдээс авсан саналын материалыг үндэслэн баталдаг гэж байгаа ч саналын нэгтгэл, хэлэлцсэн хурлын протокол зэрэг нотлох баримтууд байхгүй байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр шинээр хийгдэхээр баталсан 1,828.2 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээнээс 725.4 сая төгрөгийн 18 ажилд иргэдийн саналыг аваагүй бөгөөд зураг төсөв хийлгэх, баяр наадмын арга хэмжээнд 79.2 сая төгрөгийг шууд баталж хэрэгжүүлсэн байна. /Хавсралт 1-ээр харуулав/.

Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргахдаа иргэдээс санал аваагүй ажлыг тусгасан, зарим багийн ИНХ журамд заасан хугацаанд хуралдаагүй, хурлын ирцийг гарын үсгээр баталгаажуулаагүй, ирц бүрдээгүй байхад хурлыг хүчин төгөлдөр болсноор тооцсон зэрэг зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 60.3.6 дахь заалтыг зөрчиж, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдээс санал аваагүй нийт 9 төрлийн 119.0 сая төгрөгийн арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Ерөө сум 5.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын төвд Wi-Fi суурилуулах ажил,
- Зүүнбүрэн сум 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хаалганы засварын ажил,
- Сайхан сум 5.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цагдаагийн тасгийн хяналтын камер засвар, пос машин худалдан авах ажил,
- Алтанбулаг сум 5.5 сая төсөвт өртөгтэй дунд сургуулийн гадаад хэлний кабинет тохижуулах ажил,
- Орхон сум 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ЕБС-ийн сургалтын кабинет тохижуулах ажил,

<sup>14</sup> 60.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: 60.3.6 Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээ;

<sup>15</sup> 12 Төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах

- Сант сум 20.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгт хүрээлэн болон хүүхдийн тоглоомын талбайд баяжилт хийх, 7.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багийн хашаа гудамжны хаягжуулалт хийх ажил,
- Хушаат сум 4.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын гудамжны хаягжуулалтыг шинэчлэх, 3.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн анги танхимыг камержуулах ажил,
- Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант, Орхон, Орхонтуул, Сант, Түшиг зэрэг 7 сум иргэдийн санал аваагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй нэг бүр нь 4.6-18.7 сая төгрөгийн өртөгтэй нийт 46.9 сая төгрөгийн асар майхан худалдан авсан байна.

2. Алтанбулаг сумын 3-р, Сант сумын 1-р баг ИНХ-ыг зохион байгуулаагүй, иргэдээс санал авч эрэмбэлээгүй байна.

3. Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10, Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 5.5-д заасны дагуу Багийн ИНХ-ыг зохион байгуулаагүй, хурал хүчин төгөлдөр болоогүй байхад иргэдийн саналыг авч эрэмбэлсэн байна. Үүнд:

- Сант сум 2-р багийн ИНХ-ын ирц бүрдээгүй,
- Баруунбүрэн, Ерөө сумдын 2, 3, Мандал сумын 1, 2, 3, 6, 7, 9, Цагааннуур, Сайхан сумдын 1-3 дугаар багууд хурлын ирцийг бүртгэж, оролцогчдоор гарын үсэг зуруулж, баталгаажуулаагүй,
- Ерөө сумын 2, 3, Цагааннуур сумын 1-3 дугаар багийн ИНХ нь иргэдийн саналыг эрэмбэлж, багийн ИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл хөтлөөгүй,
- Мандал сумын 8 багийн ИНХ-ын ирц гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй байна.

4. Алтанбулаг, Ерөө, Сайхан, Орхон, Цагааннуур, Хушаат сумд Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу багийн ИНХ-ыг 5-р сард багтааж бус 6-12 сард хуралдуулсан байна.

5. Бүх сумд ОНХС-гийн зааврын 5.3-д заасны дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг багийн ИНХ-аар хэлэлцүүлэх хурлын зарыг айл өрх бүрт хүргэж, хүлээн авсан айл өрх бүрээр баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлахад иргэд, олон нийт хэрхэн оролцож байгааг судлах зорилгоор 11 сумын 20-60 насны 257 иргэнийг хамруулан 6 асуудлаар судалгаа авахад 43 хувь нь хангалттай оролцдог, 32.0 хувь нь хаяа оролцдог, 25 хувь нь огт оролцдоггүй, энэ талаарх мэдээлэл байхгүй гэсэн дүн гарсан байна. /Хавсралт 2-оор харуулав/.

**2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй, магадлал хийлгээгүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29.4<sup>16</sup>, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.5, 12.2.7, 6.3.3, мөн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар

<sup>16</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад, зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгана.

баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7 дахь заалтуудаар хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг ИТХ-аар батлуулахдаа ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх зарчмыг баримтлахаар зохицуулжээ.

Гэвч аймаг, сумын ИТХ нь урьдчилан тооцоолсон зураг, төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталдаг зөрчил оршсоор байна.

Тайлант онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр баталсан 42 төсөл, арга хэмжээнээс 593.5 сая төгрөгийн өртөгтэй 12 ажлын зураг, төсөв нь 2015 онд хийгдсэн бол бусад 1,234.7 сая төгрөгийн 30 төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулсны дараа төсөвт өртөгт нь багтаан зураг, төсвийг хийлгэсэн байна.

Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр баталсан 106 төсөл, арга хэмжээнээс Баянгол, Зүүнбүрэн, Сүхбаатар, Хүдэр, Алтанбулаг, Хушаат, Шаамар сумдын нийт 51 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд урьдчилсан байдлаар зураг, төсвийг хийлгэсэн байна.

Бусад 10 сумын нийт 40 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг ИТХ-аар батлуулсны дараа, батлагдсан төсөвт өртөгт тохируулан хийлгэсэн бол дараах [247.7](#) сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг ямар ч тооцоо судалгаагүйгээр, гүйцэтгэгч компаниас ирүүлсэн саналыг үндэслэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Алтанбулаг сум гудамж талбайн засварын 6.5 сая төгрөгийн,*
- *Баруунбүрэн сум ахмадын байрны цахилгаан халаалт тавих 5.0 сая төгрөгийн,*
- *Орхонтуул сум Орхон голын гүүрний гатлага, онгоцны засвар хийлгэх 5.0 сая төгрөгийн,*
- *Жавхлант сум ус цэвэршүүлэгч худалдан авах 8.6 сая төгрөгийн, Сөртийн худаг засварын 5.0 сая төгрөгийн, гудамж талбайд явган зам тавих 6.5 сая төгрөгийн зэрэг нийт 20.1 сая төгрөгийн,*
- *Мандал сум Хүүхдийн тоглоомын талбай байгуулах 61.4 сая төгрөгийн, нийтийн бие засах газар барих 10.0 сая төгрөгийн, цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх 30.7 сая төгрөгийн, камержуулалтын 63.7 сая төгрөгийн зэрэг нийт 165.8 сая төгрөгийн,*
- *Түшиг сум 10.0 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй тоног төхөөрөмж худалдан авах, засвар хийх зэрэг 7 төрлийн 45.3 сая төгрөгийн.*

Түшиг сум [55.0](#) сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулах ажилд магадлал хийлгэж, хяналт тавиулаагүй байгаа нь Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.1<sup>17</sup>, 11.6<sup>18</sup>-д заасныг тус тус зөрчиж байна

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд урьдчилсан байдлаар зураг төсөв хийлгэхгүй байгааг аймаг, сумдын холбогдох албан тушаалтнуудаас тодруулахад дараах тайлбарыг өгч байлаа. Үүнд:

<sup>17</sup> Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж хэрэгжилтэд хяналт тавих.

<sup>18</sup> Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь хот байгуулалтын баримт бичигт холбогдох хууль, тогтоомж норм ба дүрэм журамд заасны дагуу улсын экспертизийн дүгнэлт гаргуулна.

- ОНХС-гийн төсвийг ОНХНС, аймгийн ОНХС-аас шууд хуваарилан баталдаг тул баталсан хуваарийн дүнд тааруулан ажлын тоо, өртгийг сонгох шаардлага тулгардаг,
- Урьдчилсан байдлаар зураг төсөв хийлгэсэн ажил ИТХ-аар батлагдахгүй тохиолдолд үр ашиггүй зардал гарах, эх үүсвэр нь шийдэгдэхгүй өр төлбөр үүсэх зэрэг эрсдэл үүсдэг,
- Ихэнх тохиолдолд зураг, төсөв гүйцэтгэгч нь ажлын хөлсийг урьдчилан шилжүүлэх шаардлага тавьдаг гэсэн байна.

Хэдийгээр зарим төсөл, арга хэмжээг батлахын өмнө болон батлагдсаны дараа төсөвт өртөгт нь багтаан зураг, төсвийн тооцооллыг хийж байгаа ч уг зураг, төсөв нь үнэн зөв эсэхийг магадлах ажил огт хийгдэхгүй байгаа нь төсвийг бодит зардлаас хэт өндрөөр тооцох, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.

## **2.4 Сумдад худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэлээр нэгдсэн заавар чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байх шаардлагатай байна.**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016 онд ОНХС-гийн хөрөнгөөр нийт 202 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 54 нь өмнөх оноос шилжин ирсэн байна.

Шинээр хэрэгжүүлэхээр баталсан 148 төсөл, арга хэмжээнээс баяр наадам, гэрэлтүүлгийн цахилгааны зардал гэх мэт 13 удаагийн 145.2 сая төгрөгийн арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд шууд зарцуулж, 4 удаагийн 147.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний төсөв шийдэгдээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. /Хавсралт 3-аар харуулав /

Бусад 131 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулсан нийт төсөл, арга хэмжээний 6.9 хувь буюу 9 удаагийн 935.3 сая төгрөгийн ажилд нээлттэй тендерийн,
- 55.0 хувь буюу 72 удаагийн 2,663.2 сая төгрөгийн ажилд харьцуулалтын,
- 37.4 хувь буюу 49 удаагийн 315.9 сая төгрөгийн ажилд шууд гэрээ байгуулах,
- Түшиг сум сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 55.0 сая төгрөгийн ажилд зөвлөх үйлчилгээний журмаар тус тус гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт, тендер шалгаруулалтын мэдээлэл зэргийг иргэд, олон нийтэд нээлттэй ил тод болгосноор<sup>19</sup> худалдан авах ажиллагаанд оролцогч компаниуд, иргэд, олон нийтийн зүгээс тавих хяналт сайжирч, худалдан авах ажиллагаатай холбоотой гарах зөрчил буурсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон үнэлгээний хороо, Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар томилогдсон 3-

<sup>19</sup> Тендерийг meps.gov.mn, selenge.gov.mn, e-procurement.mof.gov.mn сайтууд дээр зарлаж, тендерийн материалыг хүлээн авч, нийтэд ил тод байдлаар сонгон шалгаруулалтыг хийж байна.

7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж байна.

Харин сумдад ЗДТГ-ын тушаалаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо, ажлын хэсэг байгуулагдаж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 4 суманд худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулаагүй дараах [344.2](#) сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Ерөө сумын 34.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, 2-р багийн тоглоомын талбай барих, засварлах, 18.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бугант тосгонд гүний худаг гаргах ажлуудын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгохдоо эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг албан ёсоор мэдэгдээгүй<sup>20</sup>,
- Орхон сумын ЗДТГ нь аймгийн ОНХС-гаас эрх шилжүүлсэн 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй наадмын талбай барих ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгохдоо эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг албан ёсоор мэдэгдээгүй, барилгын ажил эрхлэх “Тусгай зөвшөөрөл”-ийн хугацаа дуусч, Барилгын хөгжлийн төвийн тодорхойлолт ирүүлсэн Самосон ХХК-ийг сонгон шалгаруулсан,
- Түшиг сум нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4-р бүлэг “Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам”-ын дагуу 55.0 сая төгрөгийн төсөв өртөгтэй сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 194 тоот тушаалаар батлагдсан “Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг”-ийг мөрдөөгүй, тендерийг үнэлэхдээ Сангийн сайдын 2008 оны 249 тоот тушаалаар батлагдсан “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”-ыг баримтлаагүй,
- Сүхбаатар сум 76.4 сая төгрөгийн гэрэлтүүлэг /Хонгор морьт 1-р багт 25ш, Салхит 3-р багт 11ш, Бор гүвээ 5-р багт 14ш, Ган зам 7-р багт 11ш/-ийн ажлын төсвийг 2 хувааж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан,
- Мандал сумын гэр хорооллын гудамж зам талбайг сайжруулах 79.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материалыг ТООЗ-ны 1.1-т “Барилга угсралтын тусгай зөвшөөрлийн хуулбар, гэрээний хамт /баталгаажуулж/ ирүүлэх” гэж заасан боловч тусгай зөвшөөрөлгүй Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ыг сонгон шалгаруулсан байна.

Дээрх байдлаас үндэслэн аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газраас сумдын ОНХС хариуцсан албан тушаалтнуудад өгөх заавар, зөвлөмж, хэрэгжилтэд нь хяналт тавих ажил хангалтгүй байна гэж дүгнэж байна.

**2.5 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээний<sup>21</sup> 4.9 хувь буюу 260.7 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.**

Төсвийн тухай хуулийн 58.2, 58.4, Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 7.2, 7.4-т аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 7-12 төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааснаас малжуулах, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль

<sup>20</sup> ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 “техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх”

<sup>21</sup> Тайлант онд нийт 5331.2 сая төгрөгийн 202 хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан.

орчныг хамгаалах, нөхөн сэргээх гэсэн 3 чиг үүргээс бусад чиг үүрэгт хамаарах 148 төсөл, арга хэмжээнд 4,213.2 сая төгрөгийг дараах зориулалтаар зарцуулахаар төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- Барилга, байгууламж, шугам сүлжээ шинээр барих, засварлах ажилд 38.3 хувь буюу 1,612.8 сая төгрөг,
- Гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг, тэдгээрийн засвар үйлчилгээний зардалд 28.6 хувь буюу 1,205.0 сая төгрөг,
- Зам, далан барих, засварлах ажилд 9.5 хувь буюу 398.7 сая төгрөг,
- Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахад 9.0 хувь буюу 377.1 сая төгрөг,
- Удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгийн болон урсгал зардалд 6.3 хувь буюу 266.0 сая төгрөг,
- Хогны универсиал трактор, нийтийн тээврийн автобус, мотоцикл худалдан авахад 3.1 хувь буюу 131.7 сая төгрөг,
- Сумын хөгжлийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах зардалд 1.7 хувь буюу 71.7 сая төгрөг,
- Баяр наадмын зардалд 2.3 хувь буюу 96.2 сая төгрөг,
- Зураг төсөв хийлгэх зардалд 1.3 хувь буюу 54.0 сая төгрөг

Хэдийгээр аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгийн ихэнхийг холбогдох хууль, журамд заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж байгаа боловч сургууль, цэцэрлэг, эмнэлэг, тохижилт үйлчилгээний газарт машин, техник, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгө худалдан авах, гэрэлтүүлэг ашиглалтын зардал, нохой устгах зэрэг тухайн байгууллагын төсвөөр гүйцэтгэж болох зардлуудыг санхүүжүүлэхэд хэт жижиглэн зарцуулж байгаа нь тус сангийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгийг холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн болон зориулалт бусаар зарцуулсан дараах 260.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ОНХС-гаас:

- Цагааннуур сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 568.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий замын ажилд 100.0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгосон<sup>22</sup>.
- Сумын удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд Цагааннуур сумын ЗДТГ-ын засварт 8.0 сая төгрөг, Мандал сумын Хэрх тосгоны Захирагчийн албаны барилгын дээвэр засварт 59.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, хэрэгжүүлсэн<sup>23</sup>.
- Аймгийн баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын <sup>124</sup>-д заасныг зөрчин 40.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Сумдын ОНХС-гаас:

<sup>22</sup> ОНХС-аас санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй давхардуулахгүй байх.

<sup>23</sup> Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 4.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх.

<sup>24</sup> Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг хэмжээг аймагт 10 сая, суманд 5 сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх уяач, харваачдад олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

- Алтанбулаг сум жишиг гудамж барихаар батлагдсан 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зориулалтыг өөрчилж, камержуулалтын урсгал засвар, Тавтай морил хаалганы засвар, гудамж талбайн тохижилтын ажилд тус тус зарцуулсан. Үүнээс гудамж талбайн тохижилтын **6.5 сая** төгрөгийн ажлыг хийж гүйцэтгээгүй боловч гүйцэтгэсэн тухай хуурамч баримт бүрдүүлэн хавсаргасан байна.
- Урсгал зардлын шинжтэй нохой устгах ажилд Алтанбулаг сум 1.5 сая төгрөг, Баруунбүрэн сум 2.0 сая төгрөг, Сайхан сум 5.0 төгрөг, Сүхбаатар сум 19.0 сая төгрөг, Зүүнбүрэн сум 0.6 сая төгрөг, хог хаягдлын зардалд 0.3 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл худалдан авахад 1.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.
- Сайхан сумын Хот тохижилтын газар нь 9.9 сая төгрөгийн төсөвтэй ашиглалтын зардлаас 3.8 сая төгрөгийн авто машины сэлбэг худалдан авсан.
- Цагааннуур сум баяр наадмын зардлыг 2.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

## **2.6 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.**

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр нийт 3,891.2 сая төгрөгийн 135 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 2,962.5 сая төгрөгийн өртөгтэй 117 ажил нь нь бүрэн, 529.0 сая төгрөгийн өртөгтэй 9 ажил нь дутуу хэрэгжиж, 399.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ажил огт хэрэгжээгүй байна. /Хавсралт 5-аар харуулав /.

Аймаг, сумдын захиалагчийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсгийн болон үнэлгээний хороодоос гэрээ байгуулах зөвлөмж өгсний дагуу ажил гүйцэтгэх, захиалагчийн хяналт хийлгэх /техник хяналтын, зураг төсөв болон зохиогчийн хяналтын/ гэрээг тус тус байгуулан ажиллажээ.

Гэрээний хэрэгжилттэй холбоотой гүйцэтгэсэн ажлыг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний хугацааг баримтлаагүй, ажлын даалгаврыг өөрчилсөн, захиалагчийн хяналт хийлгээгүй, хяналт хийлгэсэн тайлан, акт үйлдээгүй, зохиогчийн хяналт зохих журмын дагуу хийгдээгүй зэрэг зөрчил нийтлэг байдлаар оршиж байна. Эдгээр зөрчлийг дэлгэрэнгүйгээр харуулбал:

### **Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:**

- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5<sup>25</sup>, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11 дүгээр зүйлийн 11.2.2<sup>26</sup>-т заасан баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байхад ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

<sup>25</sup> ... дараах материалыг үндэслэн хянаж, санхүүжүүлнэ. Үүнд: 3.5.7. Барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтанд хүлээн авсан тухай улсын комиссын акт, техникийн комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт

<sup>26</sup> ОНХС-ийн санхүүжилтийн нээсэн эрхийг үндэслэн тухайн орон нутагт төсвийн санхүүжилт хийдэг албан тушаалтнууд зохих журмын дагуу хянаж гүйлгээг хийнэ

- *Зураг төсөв хийлгэхээр Талхун арал, Монар, Зочу Сэлэнгэ ХХК-уудад 23.0 сая төгрөгийг шилжүүлсэн ч зураг төсөв хүлээн авсан акт, зарим ажлыг гүйцэтгэх гэрээ зэрэг анхан шатны баримтуудын бүрдэл хангалтгүй байна.*
- *Ерөө сум 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бугант тосгоны нийтийн орон сууцны цахилгааны засварыг ашиглалтад оруулах комиссын актаар хүлээж аваагүй байхад үлдээгдэл 3.0 сая төгрөгийг олгосон.*

- Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 3.13<sup>27</sup>-т заасныг зөрчин захиалагч, гүйцэтгэгчийн хамтран тогтоосон акт үйлдээгүй байхад гэрээнд тусгагдсан магадлашгүй ажлын зардлыг гүйцэтгэгчид шилжүүлсэн байна. Үүнд:

- *Мандал сум замын гэрэлтүүлгийн ажилд тооцсон 1.7 сая төгрөгийн, цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх ажилд тооцсон 0.6 сая төгрөгийн магадлашгүй ажлыг хийж гүйцэтгэснийг нотлох акт үйлдээгүй,*
- *Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн нийт 23 ажилд магадлашгүй ажил тооцсоноос 15 ажлын 14.6 сая төгрөгийн ажлын төсөвт тооцоо хийгээгүй, тухайн ажлыг хийж гүйцэтгэснийг нотлох акт үйлдээгүй байна.*

- Зохиогчийн хяналтын зардалд 11.7 сая төгрөгийг шилжүүлсэн ч, зураг, төсөв зохиогчтой байгуулсан гэрээг дүгнээгүй, шаардлагатай тэмдэглэл, дүгнэлт зэргийг бүрдүүлээгүй, өөрөөр хэлбэл анхан шатны баримтаар баталгаажаагүй гүйлгээ хийсэн нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавигдах хяналт хангалтгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

**Гүйцэтгэх ажлын даалгаврыг зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн байгаа нь Барилгын тухай хуулийн 37.4<sup>28</sup> дэх заалтыг зөрчиж байна. Үүнд:**

- *Сүхбаатар сумын 5-р багт 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 гүний худаг барих ажлын зориулалтыг өөрчилж, 2 гүний худаг болгон 2 айлын хашаанд бариулсан байна.*
- *Аймгийн орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 79.9 сая төгрөгийн өртөг бүхий төв цэнгэлдэх хүрээлэнгийн дотор талбайн тэгшилгээ, хөрс солих ажлын нэр /аймгийн хөл бөмбөгийн талбайн газар шорооны ажил хийлгэхээр анх төсөв батлуулсан/, тоо хэмжээ, даалгаврыг өөрчилсөн.*

**Гэрээнд заасан хугацаанд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй, гэрээнд хугацаа сунгасан нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна. Үүнд:**

- *Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Ерөө суманд баригдсан 114.1 сая төгрөгийн өртөгтэй хөл бөмбөгийн талбай, Түшиг суманд баригдсан 50.0 сая төгрөгийн өртөг бүхий үерийн усны далан, Сүхбаатар суманд баригдсан 72.9 сая төгрөгийн өртөгтэй төмөр замын байрнуудын засвар, 34.1 сая төгрөгийн өртөг бүхий Сүхбаатар сумын 2-р сургуулийн дээвэр*

<sup>27</sup> Төсвийн магадлашгүй ажлын зардлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон актын дагуу олгох бөгөөд актаар тогтоогоогүй магадлашгүй ажлыг санхүүжүүлэхгүй.

<sup>28</sup> Захиалагч барилга, байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүй өөрчлөхийг хориглоно.

засварын ажлууд гэрээний хугацаандаа дуусаагүй байхад хугацаа сунгасан нэмэлт өөрчлөлт хийгээгүй,

- Мандал суманд 61.4 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай барих, 79.5 сая төгрөгийн гэр хорооллын зам тавих, 63.7 сая төгрөгийн камержуулалтын ажлууд гэрээний хугацаандаа дуусаагүй, гэрээнд хугацаа сунгасан нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна.
- Сайхан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй 79.9 сая төгрөгийн өртөгтэй хөл бөмбөгийн талбай байгуулах, 18.0 сая төгрөгийн өртөгтэй бичил хорооллуудын авто зогсоол нэмэгдүүлэх ажлууд гэрээний хугацаанд ашиглалтад ороогүй бөгөөд гэрээнд хугацаа сунгасан нэмэлт өөрчлөлт хийгээгүй байна.

**Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:**

- Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.2<sup>29</sup>, 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2<sup>30</sup> дахь заалтуудыг зөрчиж дараах ажлуудад мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулаагүй байна. Үүнд:

- Түшиг сум 30.0 сая төгрөгийн өртөгтэй гэрэлтүүлэг, засвар үйлчилгээний ажил,
- Сайхан сум 79.9 сая төгрөгийн хөл бөмбөгийн талбай байгуулах, 30.0 сая төгрөгийн гудамжны гэрэлтүүлгийн ажил,
- Мандал сум 79.5 сая төгрөгийн гудамж талбайн зам засах ажил,
- Баруунбүрэн сум 18.7 сая төгрөгийн дотуур байрны дээврийн засвар, цахилгааны засварын ажил, 23.5 сая төгрөгийн фермийн хороолол руу цэвэр усны шугам татах ажил.

- Техник хяналтын гэрээг захиалагч болох сумдын ЗДТГ, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын хооронд бус гүйцэтгэгч компани болон хяналтыг хэрэгжүүлэгч Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын хооронд байгуулж байгаа нь Барилгын тухай хуулийн 37.1.4<sup>31</sup>, Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.2.5 дахь заалтыг зөрчиж байна.

Дараах 5 сумын, нийт 10 ажилд захиалагч болох сумдын ЗДТГ, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ хооронд гэрээ байгуулаагүй байна. Үүнд:

- Шаамар сумын 1-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах /техник хяналтын зардал 0.8 сая/, Дулаанхан тосгоны гэрэлтүүлэг тохижилтыг сайжруулах /0.9 сая төгрөг/,
- Хушаат сум Энх тал хорооллын цахилгаан шугамын шинэчлэлийн ажил /0.3 сая төгрөг/, ЗДТГ-ын конторын барилгын их засварын ажил /0.4 сая төгрөг/, ЭМТ-ийн бохирын шугамын засварын ажил /0.2 сая төгрөг/.

<sup>29</sup> Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс нь энэ дүрмийн 3 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна.

<sup>30</sup> энэ дүрмийн 2.1-д заасан барилга захиалагч нь мөн дүрмийн 3.1-д зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 3.2.5 “орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга захиалагчийн албаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх”

<sup>31</sup> Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулах.

- Ерөө сум 1, 2-р багийн тоглоомын талбай барих, засварлах ажил /0.6 сая төгрөг/, Бугант тосгонд гүний худаг гаргах ажил /0.3 сая төгрөг/,
- Түшиг сум гэрэлтүүлэг, засвар үйлчилгээний ажил /0.6 сая төгрөг/,
- Сант сум Хушаат багт гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /0.8 сая төгрөг/, Хушаат, Ивэн багт бэлчээрийн худаг гаргах ажил /0.6 сая төгрөг/.

- Зарим ажилд захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлсэн боловч нотлох баримт, материалыг бүрдүүлээгүй, архивын нэгж болгон хадгалаагүй байгаа нь Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоол батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.1<sup>32</sup> заалтыг зөрчиж байна. Үүнд:

- Түшиг сум 28.7 сая төгрөгийн өртөгтэй хүүхдийн тоглоомын талбайн ажил, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 50.0 сая төгрөгийн үерийн далангийн ажил,
- Сайхан сум 30.0 сая төгрөгийн өртөг бүхий 28-р цэцэрлэгийн цонх, хаалга шинэчлэх, 18.0 сая төгрөгийн бичил хорооллын автомашины зогсоол нэмэгдүүлэх ажил.
- Сүхбаатар сумын ЗДТГ нь 2016 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 141.4 сая төгрөгийн 4 хөрөнгө оруулалт, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ГХБХБГ-аар хийлгэхээр гэрээ байгуулж, 2.5 сая төгрөгийн өглөг үүсгэсэн ч хяналт тавьсныг нотлох баримт хангалтгүй байна.
- Мандал сум тайлант онд хэрэгжүүлсэн нийт 331.0 сая төгрөгийн 6 хөрөнгө оруулалт, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн талаарх тайлан, акт зэргийг хавсаргаагүй байна.

**Зураг, төсөв зохиогчийн хяналтын ажлын хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:**

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 26 хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зураг төсөв болон зохиогчийн хяналтын гэрээ /ихэнх нь Талхун арал ХХК-тай, 2-3 удаагийн ажилд ДСЦТС ХК, Бурхант Орд ХХК/ байгуулснаас 4 ажлаас бусад 1,096.8 сая төгрөгийн өртөг бүхий 22 ажилд зохиогчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлснийг нотлох тайлан, тэмдэглэл, дүгнэлтийг хавсаргаагүйгээс үндэслэн зохиогчийн хяналт хэрэгжүүлээгүй гэж үзэж байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 38.1.4<sup>33</sup>, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.2<sup>34</sup>, 4.1<sup>35</sup>, 4.9<sup>36</sup>-д заасныг зөрчиж байна.

<sup>32</sup> Захиалагч нь Иргэний хууль, Барилгын тухай хуульд зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 3.1.2 “барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, холбогдох бусад баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авах, түүнийг баталгаажуулах”, 3.1.7 “барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх

<sup>33</sup> Зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх.

<sup>34</sup> 2.9. Багийн ахлагч зураг төсөл зохиогчийн хяналт тавьсан гишүүдийн дүгнэлтийг нэгтгэж тайланг барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төслийн байгууллагуудад хүлээлгэн өгч танилцуулна.

<sup>35</sup> 4.1. Барилгын хүчин чадал, технологийн шийдэл, гүйцэтгэгч, захиалагч нарын мэргэжлийн ур чадвар, барилгын ажлыг гүйцэтгэх хугацаа, энэ дүрмийн 4.2-т заасан хяналт хэрэгжүүлэх хэлбэр зэргээс хамааруулан захиалагч, зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэгч зохиогчийн хяналтын үр дүн, зөвлөмж, шаардлагыг тэмдэглэх баримт бичгийн сонголт, бүрдлийг хамтран шийдэж, зохиогчийн хяналтын гэрээ /хавсралт 2/-ээр зохицуулна.

<sup>36</sup> 4.9. Зураг төсөл зохиогчийн хяналтын тэмдэглэлийн эх хувийг барилга байгууламжийг ашиглалтанд оруулах үед архивт, хуулбар хувийг зураг төсөл зохиогч байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

- Сумдын хувьд Сант сум 4, Зүүнбүрэн, Сүхбаатар сумд тус бүр 1 ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд бусад сумд зохиогчийн хяналтын зардлыг тооцож гэрээнд тусгаагүй, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж хэвшээгүй байна.

## 2.7 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1<sup>37</sup>, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8 дугаар зүйлийн 8.6<sup>38</sup>-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэнэ.

Хэдийгээр сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, хариуцах эзэнтэй болгосон ч аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэлд тусгах талаар аймгийн ЗДТГ болон Орон нутгийн өмчийн албанаас харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлэхгүй байгаагаас хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зөрчил давтагдан гарсаар байна. /Хавсралт 6 –аар харуулав/ Үүнд:

- *Тайлант онд ашиглалтад орсон 395.0 сая төгрөгийн өртөг бүхий 11 хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй байна. Бүртгэлд тусгаагүй шалтгааныг ашиглагч байгууллагуудаас тодруулахад бидэнд зохих баримт материал ирдэггүй, аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газраас бүртгэлд тусгах талаар шийдвэр ирээгүй тул ямар өртгөөр, хэдий хугацааны ашиглалттай байхаар бүртгэлд тусгаахаа мэдэхгүй байна гэсэн тайлбарыг өгч байна.*
- *ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 219.5 сая төгрөгийн өртөг бүхий 5 ажлын эзэмшигч байгууллагыг шийдвэрлээгүйгээс бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал цахилгааны шугам өргөтгөх, шинэчлэх ажлуудыг сумын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэх тохиолдолд ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэргүй, нөгөө талаас Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-ийн бүртгэлд тусгах тохиолдолд хувийн компанийн өмчлөлд шилжих зэрэг хүндрэлтэй асуудал үүсч байгаа тул эзэмшил нь тодорхойгүй байна.*

### Бүлэг 3

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг зааврын дагуу тайлагнасан уу.**

*ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт гүйцэтгэх байгууллагууд хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй байна.*

## 3.1 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

<sup>37</sup> Аж ахуйн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

<sup>38</sup> ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ.

ОНХС-гийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд аймаг болон 9 сумын ИТХ-аас хяналт тавиагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр зүйлийн 9.1<sup>39</sup>-д заасныг зөрчиж байна. Үүнд:

- *Ерөө, Жавхлант, Орхонтуул, Сүхбаатар сумд ИТХ-ын дэргэдэх “Хяналтын хороо”-г байгуулаагүй, хяналт тавьж, үнэлгээ хийгээгүй,*
- *Алтанбулаг, Мандал, Хушаат, Түшиг, Шаамар сумд ИТХ-ын дэргэдэх “Хяналтын хороо”-г байгуулсан боловч хяналт шалгалт хийгээгүй,*
- *Аймгийн ИТХ нь хяналт хийх эрх зүйн орчин тодорхойгүй учраас хяналт шалгалт хийгээгүй гэсэн тайлбарыг өгч байна.*

Харин Баруунбүрэн, Баянгол, Зүүнбүрэн, Орхон, Сант, Сайхан, Хүдэр, Цагааннуур зэрэг 7 сум ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороог 4-5 хүний бүрэлдэхүүнтэй /ИТХ-ын тэргүүлэгчид, нягтлан бодогч, иргэдийн төлөөллөөс бүрдсэн/ байгуулж, жилд 1-3 удаа хяналт шалгалт хийжээ. Хяналт шалгалтаар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний явц, чанар байдлыг биечлэн үзэж тайлан бичсэн бөгөөд ямар нэгэн зөрчил илрээгүй гэж тайлагнасан байна.

Бусад иргэд, иргэний нийгмийн байгууллага болон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл аймаг, сумдын ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд аймгийн Аудитын газраас гүйцэтгэж буй хөндлөнгийн хяналтаас бусад ямар ч хяналт шалгалт хийгдээгүй байна.

Иймээс цаашид аймаг, сумдын ИТХ, төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба зэрэг байгууллагууд холбогдох хууль, эрхийн актын дагуу тус сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт гүйцэтгэж, сангийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулж байх шаардлагатай байна.

### **3.2 Сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг авч, тайланд дүн шинжилгээ хийн зөвлөмж хүргүүлэх ажил хийгдээгүй байна.**

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-гийн заавар”-ын 10.1<sup>40</sup>, 10.2<sup>41</sup>, 10.3<sup>42</sup>-д заалтуудаар ОНХС-гийн хэрэгжилтийн явцын тайланг хагас жилээр болон жилийн эцэст аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, уг тайланд аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ажлын хэсэг дүн шинжилгээ хийн, зохих байгууллага албан тушаалтнуудаар хэлэлцүүлж, гарсан

<sup>39</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

<sup>40</sup> Сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас ижлийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилийн тайланг 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах эрх бүхий ЗДТГ-ын ХБХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсгийн Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

<sup>41</sup> Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээхний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ.

<sup>42</sup> Аймаг, нийслэл ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гаргасан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны ОНХС-ийн хэлтэст ирүүлнэ.

санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс тус тайланг бүх сумдаас авч, зохих арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байгаагаас 9 сум /Алтанбулаг, Ерөө, Орхонтуул, Сайхан, Сант, Хушаат, Цагааннуур, Түшиг, Шаамар/ хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй, 8 сум /Баруунбүрэн, Баянгол, Мандал, Жавхлант, Зүүнбүрэн, Орхон, Сүхбаатар, Хүдэр/ тайлан ирүүлсэн ч түүнд дүн шинжилгээ хийж санал, зөвлөмж боловсруулаагүй байна.

Цаашид аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, сумдаас хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд авах, тайланд дүн шинжилгээ хийж, зохих санал, зөвлөмжийг хүргүүлж байх шаардлагатай бөгөөд энэ нь аймгийн хэмжээнд ОНХС-гийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу нэгдсэн ойлголтоор хэрэгжүүлэх, гарч буй зөрчлийг тухай бүр засаж залруулах ач холбогдолтой юм.


### **3.3. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний мэдээллийг нийтэд ил тод хүргэж байна.**

Аймаг, сумд ОНХС-гийн хөрөнгийн санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээллийг Шилэн дансны тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 11 дүгээр зүйлийн 11.2.3<sup>43</sup>-т заасны дагуу нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй байдаг.

ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, Сангийн яам, Худалдан авах ажиллагааны болон аймгийн цахим хуудсуудаар тухай бүр мэдээлж байгаа бөгөөд аудитын явцад аймаг болон сумдын ЗДТГ-ын мэдээллийн самбарыг үзэж танилцахад санхүүгийн мэдээллийн, ил тод байдлын, худалдан авах ажиллагааны мэдээллийн самбарт мэдээлэл байршуулсан байлаа. Үүнд:

- *Аймгийн ЗДТГ-ын СТСХ болон Ерөө сумын Санхүүгийн албанаас орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн мэдээллийг самбараар мэдээлсэн байна.*

*Ерөө сум Худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулдаг тусгай самбар байгуулсан байдал.*



*Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулсан самбар.*



<sup>43</sup> Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна.

- Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn), Сэлэнгэ аймгийн [selenge.gov.mn](http://selenge.gov.mn), Сангийн яамны [mof.gov.mn](http://mof.gov.mn) цахим хуудсуудаар тус сангийн худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн мэдээллийг нийтэд хүргэсэн байна.

Сэлэнгэ аймгийн [selenge.gov.mn](http://selenge.gov.mn) цахим хуудсаар мэдээлсэн байдал

| № | Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр              | Батлагдсан төсөвт өртөг | Гэрээний дүн | Санхүүжилтийн хэмжээ | Нийлүүлэгчийн нэр, хаяг            | Огноо      |
|---|----------------------------------------------------------|-------------------------|--------------|----------------------|------------------------------------|------------|
| 1 | Алтанбулаг, СБ сумдад нийтийн бие засах газар барих      | 55,000,000₮             | 55,000,000₮  | 29,971,512₮          | Сүлдханба ХХК, Талхун Арал ХХК     | 2016-12-22 |
| 2 | Цагааннуур суманд 1,2 км хатуу хүчилтэй зам тавих        | 651,910,100₮            | 100,000,000₮ | 100,000,000₮         | Сэлэнгэ Есөн эрдэнэ ХХК            | 2016-12-22 |
| 3 | Ерөө суманд хөлбөмбөгийн талбай барих                    | 140,000,000₮            | 114,083,496₮ | 114,083,496₮         | Талхун арал ХХК, ТЭТУ ХХК          | 2016-12-16 |
| 4 | СБ сумын Хонгорморьт 1-р багт тогтоомын талбай байгуулах | 25,000,000₮             | 24,999,878₮  | 24,999,878₮          | Талхун арал ХХК, Хүчит Сэлэнгэ ХХК | 2016-12-15 |

Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдал.

| № | ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ                                                                                                                                                 | 2016<br>1 сар | 2016<br>2 сар | 2016<br>3 сар | 2016<br>1-р<br>уулрал | 2016<br>4 сар | 2016<br>5 сар | 2016<br>6 сар | 2016<br>Хавас<br>жил | 2016<br>7 сар | 2016<br>8 сар | 2016<br>9 сар | 2016<br>3-р<br>уулрал | 2016<br>10 сар | 2016<br>11 сар | 2016<br>12 сар | 2016<br>Бүтэн<br>жил |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------|---------------|-----------------------|---------------|---------------|---------------|----------------------|---------------|---------------|---------------|-----------------------|----------------|----------------|----------------|----------------------|
| 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)                                                                                                   | ✓             | ✓             | ✓             | -                     | ✓             | ✓             | ✓             | -                    | ✓             | ✓             | ✓             | -                     | ✓              | ✓              | ✓              | ✓                    |
| 2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт (Бүтэн жилээр, Бүтэн жилээр)                               | -             | -             | -             | -                     | -             | -             | -             | -                    | -             | -             | -             | -                     | -              | -              | -              | ✓                    |
| 3 | Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)                                                                                                                                     | -             | -             | -             | -                     | -             | -             | -             | -                    | -             | -             | -             | -                     | -              | -              | -              | ✓                    |
| 4 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмжээний шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хавас жилээр, Уулрал бүр, Сар бүр) | ✓             | ✓             | ✓             | ✓                     | ✓             | ✓             | ✓             | ✓                    | ✓             | ✓             | ✓             | ✓                     | ✓              | ✓              | ✓              | ✓                    |

| Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн төлөвлөгөө » Сэлэнгэ » Зүүнбүрэн сум » |             |           |           |           |            |            |            |            |           |           |           |
|------------------------------------------------------------------------------|-------------|-----------|-----------|-----------|------------|------------|------------|------------|-----------|-----------|-----------|
| Төрөл                                                                        | Нийт        | 1 -р сар  | 2 -р сар  | 3 -р сар  | 4 -р сар   | 5 -р сар   | 6 -р сар   | 7 -р сар   | 8 -р сар  | 9 -р сар  | 10 -р сар |
| Төлөвлөсөн шилжүүлэг                                                         | 156,032,700 | 2,063,000 | 4,663,700 | 4,010,400 | 10,637,100 | 4,783,600  | 5,207,200  | 14,065,800 | 8,057,900 | 6,509,700 | 1         |
| Санхүүжилт                                                                   | 160,812,700 | 0         | 3,600,000 | 0         | 17,774,200 | 4,783,600  | 10,207,200 | 15,000,000 | 0         | 0         | 4         |
| Төлөвлөсөн үлдэгдэл                                                          | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Бодит үлдэгдэл                                                               | 6,932,860   | 0         | 0         | 0         | 0          | 6,932,860  | 0          | 0          | 0         | 0         |           |
| Төлөвлөсөн ашиг                                                              | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Бодит ашиг                                                                   | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Төлөвлөсөн бусад                                                             | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Бодит бусад                                                                  | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Төлөвлөсөн хандив                                                            | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Бодит хандив                                                                 | 0           | 0         | 0         | 0         | 0          | 0          | 0          | 0          | 0         | 0         |           |
| Төлөвлөсөн нийт                                                              | 156,032,700 | 2,063,000 | 4,663,700 | 4,010,400 | 10,637,100 | 4,783,600  | 5,207,200  | 14,065,800 | 8,057,900 | 6,509,700 | 1         |
| Бодит нийт                                                                   | 167,745,560 | 0         | 3,600,000 | 0         | 17,774,200 | 11,716,460 | 10,207,200 | 15,000,000 | 0         | 0         | 4         |

| Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн төлөвлөгөө » Сэлэнгэ » Зүүнбүрэн сум » |              |                     |             |                |
|------------------------------------------------------------------------------|--------------|---------------------|-------------|----------------|
| Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр                                | Төсөвт өртөг | 2016 оны төлөвлөгөө | Санхүүжилт  | Бусад мэдээлэл |
|                                                                              | 0            | 0                   | 0           |                |
| Гүний худаг                                                                  | 6,132,900    | 6,132,900           | 6,132,860   | Дэлгэрэнгүй    |
| ХАЛУУН УСНЫ БАРИЛГА                                                          | 117,553,000  | 117,553,000         | 117,552,953 | Дэлгэрэнгүй    |
| Хогийн цэг гэрэлтүүлэгийн арчлалт хамгаалалт,ногооны техник тоно             | 19,588,500   | 19,588,500          | 12,446,570  | Дэлгэрэнгүй    |
| Хүүхэд залуучуудын спорт тоглоомын талбай                                    | 19,471,300   | 19,471,300          | 19,570,771  | Дэлгэрэнгүй    |
| бэлр наадам                                                                  | 5,000,000    | 5,000,000           | 5,000,000   | Дэлгэрэнгүй    |
| "Нийт"                                                                       | 167,745,700  | 167,745,700         | 160,703,154 |                |

- 
- # СЭЛЭНГЭ АЙМАГ ЗҮҮН БҮРЭН СУМ 2008 – 2016 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ
- ## • ТӨРИЙН ЗАХИРГАА
- 
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт 500 сая төгрөгөөр "Зинэ" дүрэмт, тээврийн газрын барилгын ажлын гүйцэтгэл.
- Балгасхайн гүний царамжит хөндөгчийн үйлчилгөөр байгуулах ажлыг 168055000 төгрөгөөр хөгжүүлж байна.
- 
- ## • ГАДААД ХАРИЦАА
- 
- Сумын Зүүн мөндийн тавь, Солонгос улсын амьт шарьт хамтны хамтлагийн дүрэмт Солонгос улсын амьт шарьт 10-15 нас, 2016 он 12-р сард сумын иргэдэд үзэж өгөхөөр, зөний үйлчилгээг үнэ төлбөргүй хийж байна.
- 
- АНУ-ын САВР КЭЛ байгууллагаар хавтгай гар дүрсийг үргэлжлэн зохион байгуулж нэлээд 15 хүүхдэд хяналт гарсан.
- ## • ӨРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БҮРЭН ДҮНД СҮРГҮҮЛБ
- 
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт орлого заалтыг 100 сая төгрөгөөр Борж-ногтой дунд сургуульд оруулж байна.
- 
- Иргэдийн чөлөөт цэврийг зөв боловсон өргөжүүлж, ил тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж зорилгоор спорт заалтыг 6,000,000 төгрөгийн тэнгэр хөрөнгийг оруулж байна.
- 
- Алгачийн хөрөнгө оруулалтаар 1000 сая төгрөгөөр өргөмж боловсролын бүрэн дүнд сургуулийн савангын төлөвлөгөөг зөвөр үйлчилгээг хөгжүүлж, тэд сургалтын бие засааг хөгжрөх, 8 гар утасны үйлд, 9 үйлчилгээний чөлөөт хөрөнгө оруулалтаар оруулж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1000 сая төгрөгөөр 7-8 хүүхдийн дотуур байрны өмчлөлт оруулж байна.
- 
- Хүүхдийн тээврийн бүрн боловсролын өргөмж сайжруулах зорилгоор 100 хүүхдэд бүрэлчтэй ширээг хандил олгожээ.
- Балгасхайн алгачийн хөрөнгө оруулалт 10 сая төгрөгөөр боловсролын бүрэн дүнд сургууль өргөмж дотуур байрныг оруулж байна.
- 
- Сургуулийн дотуур байрныг зөвөр үйлчилгээ, хамт хамтны бүхэл дотуур үйлчилгээг 3,335,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3,335,000 төгрөгөөр хөгжүүлж байна.
- 
- Өрхний Засаг даргаар Өрхнийн боловсролын бүрэн дүнд сургуульд 7 хүүхдэд дотуур байрныг оруулж, үйлчилгээний хөрөнгө оруулж байна. 1,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгээр үйлчилж байна.
- 
- Орш нүүдлийн хөгжлийн алгачийн хөрөнгө оруулалт 100 сая төгрөгөөр хотуу, хамтны алгач, сан-төхөөрлийн хөрөнгө оруулж байна.
- 
- 
- 

26

### 3.4. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын зарим заалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Аудитын явцад Сангийн сайдын 2012 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын зарим заалтуудыг тодорхой болгох шаардлагатай дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн зааварт санхүүжилт олгоход баримтлах журам, зааврыг тодорхой тусгаж өгөх, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгоход бүрдүүлэх баримт материалын жагсаалтад магадлашгүй ажлын төсөв, акт, зохиогчийн хяналтын тэмдэглэл, дүгнэлтийг бүрдүүлсэн байхаар нэмж оруулах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 5.1<sup>44</sup>, 5.3<sup>45</sup> дахь заалтын дагуу багийн Засаг дарга тухайн орон нутгийн айл өрх бүрээс санал авах, авсан саналыг эрэмбэлж ИНХ-ын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө айл өрх бүрт хүргэж, гарын үсгээр баталгаажуулахаар заасан нь хүн хүчний /сумдын баг нь ихэнхдээ багийн Засаг дарга, нийгмийн ажилтнаас бүрддэг/ болон санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдаг багийн хэмжээнд хүндрэлтэй байна.
3. Зааврын 12 дугаар бүлэгт заасан хариуцлага тооцох заалт нь тодорхой бус учир уг журмыг мөрдөөгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд ямар хариуцлагыг хэрхэн ногдуулах талаар тодорхой болгох шаардлагатай байна.

### 3.5 Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 82.5 хувьтай байна.

ОНХС-гийн хөрөнгийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар, 2,161.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 20 албан шаардлага, 8.0 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 19 зүйлийн зөвлөмж өгөгдсөн бөгөөд төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлагыг 92.0 хувьтай, зөвлөмжийг 55.4 хувьтай хэрэгжүүлсэн байна. /Хавсралт 6-гаар харуулав /.

Аймгийн удирдлагад өгөгдсөн 12 зөвлөмжөөс 3-г нь хэрэгжүүлээгүй, 4-ийг дутуу хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хэрэгжээгүй зөвлөмж:

- ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хяналтын хороог байгуулж, ажиллуулах.
- ОНХС-гийн эх үүсвэрийг зөвхөн ОНХНС-гаас хуваарилагдсан хөрөнгөөр бүрдүүлэх бус хуулинд заасан бусад эх үүсвэрээр бүрдүүлэх, нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар

<sup>44</sup> Сум, дүүрэг, баг, хорооны түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” батлах тухай Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалыг баримтална.

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамын 12.2.1 а/ баг, хорооны иргэдээс санал асуулгыг авахдаа санал асуулгын хуудсаар, бүлгийн ярилцлага, цахим хэлбэрээр авна, 12.2.1 б/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1-р хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1-р улиралд багтаан хүргүүлнэ.

<sup>45</sup> Баг, хорооны Засаг дарга Нийтийн хурлын зарыг хурал болохоос 2 долоо хоногийн өмнө тухайн баг, хорооны айл өрх бүрт хүргэж, зар хүлээн авсан гарын үсгийг айл өрх бүрээс авч баталгаажуулна.

гүйцэтгүүлж, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллах.

Дутуу хэрэгжсэн зөвлөмж:

- Иргэдийн саналаар баталгаажаагүй, ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-гийн төлөвлөгөөнд тусгасныг батлахгүй байх.
- ОНХС-гийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгүүдийг бүртгэл, тайланд бүрэн тусгах.
- Иргэдийн саналыг авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах.
- Ажлын явц, гүйцэтгэлд тавигдах захиалагчийн хяналтын чанарыг сайжруулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид гэрээний дагуу алданги, хариуцлага тооцох.

Өмнөх аудитаар Сүхбаатар сумын Засаг дарга М. Үүрийнтуяад өгөгдсөн аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Сүхбаатар хотын зүлэгжүүлэлт хийх” ажлын үлдэгдэл 14.4 сая төгрөгийг аймгийн ОНХС-гийн дансанд төвлөрүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аймгийн Аудитын газраас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ОНХС-гийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил буурахгүй байна.

#### АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

ОНХС-гийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар аймгийн хэмжээнд нийт **2,397.2 сая төгрөгийн** зөрчил илэрснээс **20.9 сая төгрөгийн** зөрчилд нөхөн төлөх 2 төлбөрийн акт тогтоож, **1,126.7 сая төгрөгийн** зөрчилд зөрчлийг арилгуулах 15 албан шаардлага, **1,249.6 сая төгрөгийн** зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмж хүргүүлж байна.

*/Хавсралт 7-гоор харуулав /.*

#### ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цулуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

1. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан нэр төрөл бүрээр төлөвлөж, бүрдүүлэхгүй байна.
2. ОНХС-гийн орлогын шилжүүлгийг сумдад хуваарилахдаа 3 итгэлцүүрийг харгалзуулан тооцож байна.
3. ОНХС-гийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоо хангалтгүй байна.
4. ОНХС-гаар зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байгаагаас гадна хийгдсэн зураг, төсөв нь үнэн зөв эсэхийг магадлах ажил огт хийгдэхгүй байгаа нь төсвийг бодит зардлаас хэт өндрөөр тооцох, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.

5. Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд холбогдох хууль, журмыг бүрэн хэмжээгээр мөрдөхгүй байна.
6. ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрийг зориулалт бусаар зарцуулах зөрчил оршсоор байна.
7. ОНХС-гийн хөрөнгийн тодорхой хэсгийг машин, техник, тоног төхөөрөмж худалдан авах, урсгал зардлыг санхүүжүүлэх зэргээр тухайн байгууллагын төсвийн цоорхойг нөхөх эх үүсвэр болгон, хэт жижиглэн зарцуулж байгаа нь тус сангийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулж байна.
8. Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс тавих хяналт хангалтгүй байна.
9. ОНХС-гийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудад зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж хэвшээгүй байна.
10. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн зарим хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаагүй байна.
11. Аймаг, сумдын ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилтийн байдалд аймгийн Аудитын газраас гүйцэтгэж буй хөндлөнгийн хяналтаас бусад ямар ч хяналт шалгалт хийгдэхгүй байна.
12. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний мэдээллийг нийтэд ил тод хүргэж байна.
13. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 82.5 хувьтай байна.

### ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

#### **Аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаад:**

1. ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хяналтын хороог байгуулж, ажиллуулах.
2. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлж буй төсөл, арга хэмжээний зураг, төсөв, ТЭЗҮ нь хийгдсэн эсэх, холбогдох зөвшөөрлүүд шийдэгдэж, иргэдийн саналаар баталгаажсан эсэхийг хянаж, баталж байх.

#### **Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:**

1. Иргэдийн саналыг авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах.
2. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг ТЭЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар гүйцэтгүүлж, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлэх.
3. Сумын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг томилон ажиллуулах.
4. ОНХС-гийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тухай бүр тогтоож, Орон нутгийн өмчийн газарт жагсаалт хүргүүлэн, бүртгэлд тусгуулж байх арга хэмжээ авах.

5. Аймгийн Аудитын газраас жил бүр гүйцэтгэж буй аудитаар зөрчил давтагдан гарч буй шалтгааныг судлан, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

**Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:**

1. Ажлын явц, гүйцэтгэлд тавигдах захиалагчийн хяналтын чанарыг сайжруулах, магадлашгүй ажлын төсөв, зохиогчийн хяналтын тайлан, дүгнэлт зэргийг үндэслэн санхүүжилтийг олгох зөвшөөрөл өгч байх.

**Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт**

1. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороогоор гүйцэтгүүлж, дүнг хэлэлцэж байх.
2. Багийн ИНХ-аас ирүүлсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх ажлыг журмын дагуу зохион байгуулж, баримтжуулах.
3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналаар дэмжигдээгүй, ТЭЗҮ, зураг, төсөв урьдчилан хийгдээгүй ажлыг тусгаж, батлуулахгүй байх.
4. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.
5. Ерөө, Сант, Сайхан, Түшиг сумд 2013 оноос үүссэн 8.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах.
6. Дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээг гүйцээж, ашиглалтад оруулах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА  
Б.БАТМӨНХ  
Б.ЭРДЭНЭЗУЛ